

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

АГУУЛГА

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА	1
I.1 Төслийн нэр	1
I.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэлг	1
I.3 Газар зүйн байршил:.....	1
1.4 Ордын нөөц	3
1.5 Ашиглалтын систем	3
II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ	4
II.1 Байгаль орчны онцлог	4
II.2 Нийгэм эдийн засаг	4
III. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ	5
III.1 Агаарын чанар	5
III.2 Хөрсөн бүрхэвч	5
III.3 Гадаргын болон газрын доорх ус	6
III.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл	6
III.5 Ургамлан нөмрөг	7
III.6 Амьтны аймаг	7
III.7 Нийгэм эдийн засаг	8
IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ	9
V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	10
VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	12
VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ	13
VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
IX. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ	13
X. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	14
XI. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ	15
XII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР	16
XIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ	17
XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ.....	18

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

I. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

I.1 Төслийн нэр

MV-000456 ашиглалты тусгай зөвшөөрлийн дугаартай “Мухар эрэг, өвөр чулуут, сайрын худаг” алтны шороон ордыг ил уурхайн аргаар ашиглах төсөл:



Зураг № 1. Төслийн талбай

I.2 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл


Хүснэгт № 1 Төсөл хэрэгжүүлэгчийн мэдээлэл

Төсөл хэрэгжүүлэгч	“Монголболгаргео” ХХК
Улсын бүртгэлийн дугаар	9019036062
Регистрийн дугаар	2550245
Хаяг	Улаанбаатар хот, Сонгино хайрхан дүүрэг, 21-р хороолол, Монголболгаргео ХХК-н байр
Утас	631998, 635514

I.3 Газар зүйн байршил:

Мухар-эргийн алтны шороон орд нь Улаанбаатар хотоос 710 км, Баянхонгор аймгийн төвөөс баруун хойш 70 км-т Галуут сумын нутагт, Хангайн нурууны уулын тойргийн их мужид багтах ба далайн түвшнээс дээш 2300-2600 метр өндөрт уулсын сархиаг болон уулс хоорондох хөндий, сайр жалга дамнан уулархаг хэсэгт байрладаг.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ



Зураг № 2. Төслийн талбайн байрлал

Хүснэгт № 2. Ордын газарзүйн олбилцол

1	100° 5' 40.51"	46° 23' 41.58"
2	100° 6' 15.51"	46° 23' 41.58"
3	100° 6' 15.51"	46° 24' 8.58"
4	100° 5' 30.52"	46° 24' 8.58"
5	100° 5' 30.52"	46° 23' 51.58"
6	100° 5' 0.51"	46° 23' 51.58"
7	100° 5' 0.51"	46° 23' 26.58"
8	100° 5' 25.52"	46° 23' 26.58"
9	100° 5' 25.5"	46° 20' 51.57"
10	100° 5' 55.51"	46° 20' 51.57"
11	100° 5' 55.51"	46° 20' 31.57"
12	100° 6' 25.5"	46° 20' 31.57"
13	100° 6' 25.5"	46° 21' 51.58"
14	100° 7' 20.5"	46° 21' 51.58"
15	100° 7' 20.5"	46° 21' 31.57"
16	100° 7' 35.5"	46° 21' 31.57"

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

17	100° 7' 35.5"	46° 21' 56.07"
18	100° 6' 25.5"	46° 21' 56.46"
19	100° 6' 25.52"	46° 22' 36.58"
20	100° 6' 59.5"	46° 22' 36.58"
21	100° 6' 59.5"	46° 22' 51.58"
22	100° 7' 20.52"	46° 22' 51.58"
23	100° 7' 20.52"	46° 23' 1.58"
24	100° 5' 40.51"	46° 23' 1.58"

1.4 Ордын нөөц

Ордын дунд хэсэгт хайгуулын 0410-040 шугамын хооронд 31-н блокт тооцоо хийж В, С зэргээр нөөцийг нь тогтоов. 0410-040-р шугамуудын хооронд алт агуулагч давхаргын үзүүлэлт маш тогтвортой жигд, 8 блокт хуучин хайгуулын материалыг ашиглан шинээр нөөцийн тооцоог гүйцэтгэсэн. Хайгуулын ажлыг түргэн хийж гүйцэтгэх үүднээс цохилтот өрөмдлөгөөр ажил хийж хайгуулын зарим шугамд шурф нэвтрэлтээр гүйцэтгэсэн.

Нөөцийн тооцооны үр дүнгийн хайгуул хийсэн талбайн ерөнхий үзүүлэлтүүд:

- Хучаас хурдасны зузаан - 0.72 м
- Алттай давхаргын зузаан – 1.5 м
- Хучаас хурдасны эзэлхүүн- 438.57 мян.м3
- Алттай давхаргын эзэлхүүн- 910.42 мян.м3
- Алтны дундаж агуулга /шлих/ - 238 мг/м3, /хим.цэв/-2226 мг/м3
- Алтны нөөц В+С зэргээр/шлих/ - 226.14 кг, /хим.цэв/ - 214.84 кг

1.5 Ашиглалтын систем

Ил уурхайн хүрээнд тээвэргүй дотоод овоолготой ашиглалтын системийг сонгон авж ажиллаж байгаа. Ил уурхайн хэлбэр, хэмжээ, чулуулгийн технологийн шинж чанар зэрэг суурь нөхцөлүүдийг үндэслэн дараах механикжуулалтын бүтцийг хөрс хуулалт, олборлолтын ажилд тохиромжтой байна.

II. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ БҮС НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН НИЙГЭМ ЭДИЙН ЗАСГИЙН ТОДОРХОЙЛОЛТ

II.1 Байгаль орчны онцлог

Баянхонгор аймгийн хойд хэсэгт: - Улаанбаатар хотоос 730км, - Аймгийн төвөөс 90км зайд байрладаг. Баянхонгор аймгийн Эрдэнэцогт, Баяновоо, Бөмбөгөр, Заг, Жаргалант болон Архангай аймгийн Чулуут, Их тамир, Булган сумдтай хиллэдэг.

Далайн төвшнээс дээш 1945-2500 м өргөгдсөн. Физик газарзүйн хувьд Хангайн нурууны салбар уулсын мужид, багтдаг. Газар хөдлөлийн эрчим 7 балл. Сумын нутаг дэвсгэр нь уул, гүвээ толгод бүхий тал хээр мал аж ахуй болон газар тариалан эрхлэхэд тохиромжтой. Хуурайдуу сэрүүн зунтай, хахир өвөлтэй.- 1 дүгээр сарын дундаж Температур -40,3С- 7 дугаар сарын дундаж Температур + 27,3С- Жилийн дундаж салхины хурд 0,2м/с- Жилийн хур тунадасны нийлбэр 213,2 мм

II.2 Нийгэм эдийн засаг

Баянхонгор аймгийн Галуут сум нь 1923 онд байгуулагдсан, хуучнаар Сайн ноён хан аймгийн Дашдоо гүний хошуу. Хайрхан, Сүмбэр, Үнэгт, Баяннуур, Мандал, Баянхошуу 6 багтай нийт 1240 өрхийн 4217 хүн амьдардаг байна.

Мал аж ахуй: Сумын хэмжээнд 184529 толгой малтайгаас 110 тэмээ, 10592 адуу, 19482 үхэр, 81975 хонь, 72370 ямаа байна. Нийт малын дүнтэй харьцуулахад тэмээ 0.06 хувь, адуу 5,7 хувь, үхэр 10.5 хувь, хонь 44.4 хувь, ямаа 39,2 хувь байна. Сумын хэмжээгээр нийт нутгийн шилмэл омгийн 20 хээлтүүлэгч мал тоологдсон байна

Цахилгаан хангамж: Сум нь Төвийн эрчим хүчний сүлжээнд холбогдсон. Сумын төвд 2007онд баригдсан 110/15/10 квт-ын дэд станцтай. Мандал 5 дугаар багийн төв хүртэл 18 км-т цахилгаан дамжуулах шугам татах шаардлагатай.

Дулаан хангамж: Сумын төвд Эрүүл мэндийн төв, Ерөнхий боловсролын 12 жилийн сургууль, хүүхдийн цэцэрлэг, Засаг даргын Тамгын газрын харьяа нийт 4 уурын зуухнууд ажиллаж байна.

Зам тээвэр: Сумын газар нутаг дээгүүр хангайн чиглэлийн сумдыг холбосон шороон зам дайрч өнгөрдөг. Багууд хоорондоо шороон замаар холбогддог

Ус хангамж: Сумын төвд цэвэр усны эх үүсвэрийн гүний 2 худаг, 30м³ багтаамжтай 2 усан сан, 45м³/хоног хүчин чадалтай 1 насос станц, 50м³/хоног хүчин чадалтай 1 ус зөөлрүүлэх, цэнгэгжүүлэх төхөөрөмж байна. Аж ахуйн нэгж байгууллага болон айл өрх зөөврөөр усан сангаас усаа авч байна.

III. ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛӨЛ

III.1 Агаарын чанар

- Бүтээгдэхүүн тээвэрлэх үеийн машины утаа тортог, замын тоос үүсэх
- Хүдэр боловсруулах үед үүсэх тоосжилт
- Барилга байгууламжийн орчмын шимт хөрс элэгдэж эвдэрснээс ургамлын нөмрөг талхлагдсанаас тоосжилт үүсэх
- Хатуу хог хаягдлыг цаг тухайд нь зайлуулаагүйгээс ялзарч муудан, үнэр орсноор агаар орчныг бохирдуулах зэрэг нөлөө үзүүлэхээр байна.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Машин техникийг тогтмол үзлэгт хамрагдуулж байх, янданд шүүлтүүр тавих
- Зам талбайг тогтмол усалж чийгшүүлж байх
- Ажилчдын амрах байр сууцны гадна талбайг зүлэгжүүлж тохижуулж агаарын чанарыг сайжруулах
- Хог хаягдлыг цаг тухай бүрд ачуулж, ангилах ялгаж байх
- Төсөл хэрэгжих бүхий хугацаанд агаарын тоос болон хорт бодисыг хэмжилтийн цэг бүр дээр тогтмол хийж байх зэрэг арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах боломжтой юм

III.2 Хөрсөн бүрхэвч

Төслийн зүгээс хөрсөн бүрхэвч, ургамлан нөмрөгт дор дурдсан сөрөг нөлөөллүүдийг үзүүлэхээр байна. Үүнд:

- Барилга байгууламжийн ойр орчмын шимт хөрс элэгдэж, эвдэрснээс ургамлан нөмрөг талхлагдах
- Ачиж тээвэрлэх үеийн машин техникийн хөдөлгөөнөөс хучилтгүй зам талбайн хөрс элэгдэж, эвдрэх
- Олон салаа зам гарган зорчих
- Машин техникийн эвдрэл гэмтлээс үүдэн тос, тослох материалын асгаралтаас хөрс, ус бохирдох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаяагүй, мөн ангилан ялгаагүйгээс болж хөрсийг бохирдуулах
- Ажилчдын ариун цэврийн газар болон хоолны газраас гарах шингэн хог хаягдлын байгууламж байхгүй, тэдгээрийн эвдрэл гэмтэл, дүүрэх зэрэг асуудлаас хөрс бохирдох

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Олон салаа зам гаргахгүй байх, зам талбайн тэмдэгжүүлэлт хийх
- Уурхайн гадаад болон дотоод тээврийн замыг хатуу хучилттай болгох
- Хог хаягдлыг төвлөрсөн цэгт хаях, цаг тухай бүрд ачуулах, ангилан ялгаж байх

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Цэвэрлэх байгууламж болон ариун цэврийн байгууламжийг байгаль ээлтэй технологийг сонгон ашиглах эдгээрийн эвдрэл гэмтлийг шалгаж байх
- Уурхайн машин техник төхөөрөмжийн үзлэг шинжилгээг тогтмол хийж байх

III.3 Гадаргын болон газрын доорх ус

Алтны шороон ордын хайгуулын ажил явуулсан Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт Мухар–Эрэг, Сайрын Худагын сав газруудад 1979-1980 онд Б.Энхбаяр, В.П.Шиначев нарын 1:500 000–ны масштабтай геологи гидрогеологийн иж бүрэн зураглалын ажил хийсэн талбайн баруун өмнөд хэсэгт бүрэн хамаарах бөгөөд энэ судалгаагаар гидрогеологийн нөхцөлийг тодорхойлж болох юм. Судалгаанд хамаарагдсан талбайн Хангайн нурууны атираат уулсын

гидрогеологийн нийлмэл нөхцөлтэй бүс нутагт харьяалагдана. Тухайн бүс нутагт бууж байгаа хур тунадасны усны хэмжээ, агаарын чийгшил, ус агуулагч чулуулгийн гадаргуугийн шинж төлөв нь энэхүү талбайн газрын гүний усны бүрэлдэн тогтох нөхцөлд гол хүчин зүйл болох бөгөөд газрын гүний усны бүрэлдэн тогтох орчин, эргэлтийн нөхцөлөөрөө үндсэндээ нүх сүвийн, ан цавын гэсэн 2 төрөлд багтана. Дээрхи нөхцөл болон газрын гүний ус агуулагдаж байгаа чулуулгийн литологи, давхарга зүйн ангиллыг үндэслэн дараах ус агуулагч цогцолбортой болох нь тогтоогджээ. Үүнд :

1. Орчин үеийн хурдасны ус агуулагч цогцолбор /Q iv /
2. Доод дунд рифейн ус агуулагч цогцолбор /R1-2/
3. Эхэн палезой, хожуу рифейн агуулагч цогцолбор /RZ1 –R3/

Дунд дөрөвдөгчийн мөстлөг болон эртний голын хурдас, дунд доод дөрөвдөгчийн делювиаль хурдас нь усыг зөвхөн нэвтрүүлэх үүрэг гүйцэтгэж, ус хуримтлуулагч болж чаддаггүй. Харин шаварлаг хурдсан дээр байрласан бага зузаантай сэвсгэр хурдас агаарын хур тунадасны усыг нэвчүүлэн өнгөрүүлж үндсэн чулуулгийн өргөгдсөн хэсэгт улирлын чанартай булаг шанд болон илэрдэг учир ус агуулагч давхарга болдог.

III.4 Хүний эрүүл мэндэд үзүүлэх нөлөөлөл

Ажиллагсдын ихэнх нь дуу чимээ ихтэй, температурын эрс өөрчлөлттэй нөхцөлд ажиллахаар байгаа тул мэргэжлээс шалтгаалах өвчлөлд хялбар өртөх магадлалтай юм. Түүнчлэн хөдөлмөр хамгааллын хэрэгсэл, зориулалтын ажлын нормт хувцасны хангалт, ашиглалтад анхааралтай хандаагүйгээс үйлдвэрлэлийн осолд өртөх магадлалтай байна. Байгалийн гэнэтийн аюул осолд өртөх болон хөдөлмөр хамгаалал, аюулгүй ажиллагааны дүрэм зөрчигдөх, техник хэрэгслийн элэгдэл эвдрэлээс сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Ажиллагсдыг эрүүл мэндийн үзлэгт тогтмол хугацаанд хамрагдуулж байх
- Эрүүл ахуй аюулгүй ажиллагааны заавар зөвлөмжийг өдөр бүр өгч байх
- Ажиллагсдыг хөдөлмөр хамгааллын хэрэгсэл болон зориулалтын ажлын хувцсаар хангах
- Галын аюулгүй ажиллагаа болон гамшгаас урьдчилан сэргийлэх сургалт зохион байгуулах
- Ажилчдыг хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны дүрмийг чанд сахин мөрдүүлэх тал дээр хяналт тавих

III.5 Ургамлан нөмрөг

Хүнд машин техникийн хөдөлгөөнөөр орчны ургамлан бүрхэвч алдагдах, ажиллагсад зориудын бус замаар явах, анхаарал болгоомжгүйгээс гал түймэр гарах зэрэг нь ургамлан нөмрөгт нөлөөлөн, түүний төрөл зүйлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах (хог ургамал ихсэх), зэрэг сөрөг нөлөөллүүд үүсэж болзошгүй.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис зэрэг барилга байгууламжийн гадна талбайг зүлэгжүүлэх, машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын гадна талбайг цементлэх
- Амрах байрнаас хоолны газар хүрэх зам гэх мэт явган хүний замыг нэг маршрутаар болгож цементлэн хашиж аль болох унаган ургамлыг нь гэмтээхгүй байх
- Гадна талбайг тохижуулах хашиж хамгаалах, тогтмол усалж арчилж байх
- Ажилчдын амрах байр, хоолны газар, оффис машин техникийн засварын газар болон тос тослох материалын агуулахын зэрэг барилга байгууламжид галын аюулгүй ажиллагааны буланг хийх ажилчдад хэрэглэх заавар зөвлөгөө санамжийг тогтмол өгөх, сургалт зохион байгуулах

III.6 Амьтны аймаг

Төслөөс амьтны аймагт нөлөөлөх шууд нөлөөлөл байхгүй. Төсөл хэрэгжих газар тээврийн хэрэгсэл, хүний хөдөлгөөн ихсэж, дуу чимээний нөлөөлөл зэргээс жижиг амьтад дайжих, амьдрах орчин хумигдсан. Харин ногоон байгууламжийг байгуулснаар төслийн ойр орчмын талбайд тархах зарим амьтдад амьдрахад эерэг нөлөөлөл үзүүлж болох юм.

Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээ

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

- Хөрсийг зүй зохистой ашиглах, олон салаа зам гаргахгүй байх, тогтсон нэг замаар тээврийн хэрэгслүүдийг зорчуулах.
- Ховор амьтадыг устахаас хамгаалж өөр газар шилжүүлэх болон биотехникийн арга хэмжээ авах талаар судалгаа хийх, шаардлагатай гэж үзвэл мэргэжлийн байгуулахын зөвлөмж авч хэрэгжүүлэх
- Уулын малталт, овоолгыг ан амьтанд аюулгүй байхаар байрлуулах
- Биологийн олон янз байдлыг хамгаалах төлөвлөгөөг боловсруулах

III.7 Нийгэм эдийн засаг

Төслийн үйл ажиллагаанаас нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөлөл бага ба аливаа болзошгүй нөлөөлөл нь хүний анхаарал, болгоомжгүй, хариуцлагагүй үйл ажиллагаанаас шалтгаална.

Төсөл хэрэгжих хугацаанд аж ахуйн нэгжийн орлогын албан татвар, нийгмийн даатгал болон эрүүл мэндийн даатгалын шимтгэл, авто машин болон өөрөө явагч механизмын албан татвар, эдэлбэр газар ашигласны төлбөр болон бусад татвар төлбөрийг улс болон орон нутгийн төсвийн санд оруулах бөгөөд төсөл хэрэгжсэнээр орон нутагт шинэ ажлын байр нэмэгдэх боломжтой юм.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

IV. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

“Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгад зааснаар аливаа төслийг хэрэгжүүлэхдээ байгаль орчны менежментийн төлөвлөгөөг байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний үр дүнд үндэслэн түүнийг гүйцэтгэсэн мэргэжлийн байгууллага-үнэлгээний эрх бүхий аж ахуйн нэгж боловсруулан, улмаар төсөл хэрэгжүүлэгчтэй зөвшилцөн, ерөнхий үнэлгээг хийсэн байгууллагаар хянуулах, батлагдсаны дараа хэрэгжилтийг хангаж ажиллах үүргийг тухайн төсөл хэрэгжүүлэгч хүлээхээр тусгасан.

“Монголболгаргео” ХХК -ийн Баянхонгор аймгийн Галуут сумын нутагт орших “Мухар эрэг, өвөр чулуут, сайрын худаг” алтны шороон ордын 2023 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10 дугаар сарын 29-ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан Байгаль орчны менежментийн төлөвлөгөө баримтлан боловсруулсан.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө, нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, тус байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг оролцогч, сонирхогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан бөгөөд төслийн 2023 оны менежментийн төлөвлөгөөний ажилд нийт 7.5 сая/төг зарцуулахаар төсөвлөв.

Хүснэгт № 3 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний зардал

Хэрэгжүүлсэн арга хэмжээ	БОМТ-ийн нийт зардал /сая.төг/,
Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	750.000
Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	500.000
Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	500.000
Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөлт	1.500.000
Нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө	-
Түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	-
Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	450.000
Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	360.000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	100.000
Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	100.000
Нийт	4.000.000

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

V. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллү үд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал /сая.төг	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг,стандарт аргачлал
Агаар	Уурхайн олборлолтын үе шатанд тоосжилт ихээр үүсэх үед усалгаа хийх	Үйл ажиллагааны турш	-	-	-	0.3	Үйл ажиллагааны турш	Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 Агаарт байх бохирдуулах бодисын хүлцэх хэмжээ MNS5885:2008 MNS(ISO)13688 :2000 MNS3306:1991 MNS5620:2006 MNS5623:2006 MNS5388:2004 MNS5389:2004
	Түлш шатахуун асгарч алдагдсанаас орчны агаар бохирдохоос сэргийлж техникийн засвар үйлчилгээг тогтмол хийж байх	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Үйл ажиллагааны турш	
	Тээврийн хэрэгслийн бүрэн бүтэн байдлыг шалгаж, хаалга цонхны чигжээс, хамгаалалтын үзлэгийг хийж агаарыг цэвэршүүлэх төхөөрөмж хэрэгслийг бүрэн бүтэн байдлыг хангаж ажиллах	Үйл ажиллагааны турш	-	-	-	ҮА-ны зардалд	Үйл ажиллагааны турш	
	Ажилчдын байрны тойронд мод тарих, ургамалжуулах зэргээр болон зам талбай, хаягдлыг усалж тоосжилт бууруулах арга хэмжээ авах	Үйл ажиллагааны турш	-	-	-	ҮА-ны зардалд	Үйл ажиллагааны турш	
	Уурхайн ажиллагсдад тоосноос хамгаалах хошуувч, амны маск, хүнсний нэмэлт	Үйл ажиллагааны турш	-	-	-	ҮА-ны зардалд		

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

	бүтээгдэхүүнээр ажилчдыг хангах сургалт явуулах							
Гадаргын болон газрын доорх ус	Ус ашиглалтын гэрээ байгуулах,ус ашигласны төлбөр төлөх	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Төслийн талбайд бий болсон түр зуурын урсацууд, ил задгай ус үүсвэл дээж авч Бохирдлыг тодорхойлох							
Хөрсөн бүрхэвч	Уурхайн орчны замыг стандартын дагуу тавих, тэмдэгжүүлэх ажил хийх,олон салаа зам гаргахаас сэргийлэх	Үйл ажиллагааны турш	-	-	-	0.2	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Хөрсний бохирдол үүсэхээс сэргийлэх болон олон салаа зам гаргахгүй байх талаар жолооч операторуудад сургалт явуулах	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	ШТМ-ыг стандартын шаардлага хангасан саванд хадгалах хадгалалтад хяналт тавих	Үйл ажиллагааны турш	-	-	-	ҮА-ны зардалд	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Шаардлагагүй газар ухаж сэндийчихгүй байх.	Үйл ажиллагааны турш		-	-		Үйл ажиллагааны турш	
	Төслийн талбайд ангилан ялгах тасалгаатай хогийн сав байрлуулж сард 1 удаа төвлөрсөн цэгт хаях	Үйл ажиллагааны турш		-	-	0.5	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
Нийт			1.0 сая/төг					

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

VI. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хамрах хүрээ	Хэрэгжүүлэх давтамж	Нэгжийн өртөг /сая.төг/	Нийт зардал /сая.төг/	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Техникийн нөхөн сэргээлт						
Эвдрэлд орсон талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	Дотоод овоолгод техникийн нөхөн сэргээлт хийх	Үйл ажиллагааны явцад	Дотоод овоолго 1.8 га	0.5	0.5	<ul style="list-style-type: none"> • БОНХАЖ яамны сайдын 2015 оны 3 дугаар сарын 30-ны өдөр А-138-р тушаал • “Байгаль орчныг хамгаалах тухай” • “Ашигт малтмалын тухай”, • “Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай” • MNS5915:2008 MNS5916:2008 MNS5917:2008
	Урд онуудад техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайнуудад биологийн нөхөн сэргээлтийг хийж гүйцэтгэж хүлээлгэж өгөх	Үйл ажиллагааны явцад	-	-	Үйл ажиллагааны зардлаар	
Нийт дүн сая.төг					1.0сая.төг	

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

VII. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨЛТ

Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хэмжээ	Нэгжийн өртөг, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг, стандарт аргачлал
Нөхөн сэргээлт 2024 хөтөлбөрийн хүрээнд эвдэрсэн газарт техникийн болон биологийн нөхөн сэргээлт хийх	Өвөр чулуут нэртэй газарт хувиараа ашигт малтмал олборлогч иргэдийн эвдрэлд оруулсан 5 га талбайд техникийн нөхөн сэргээлт хийх	-	-	Үйл ажиллагааны зардалаар	2023 он	
	“Тербум мод үндэсний хөдөлгөөн” хөтөлбөрийн хүрээнд 2023 онд 1000 аас доошгүй тухайн бүс нутагт дасан зохицох чадвартай модыг тариалах	-	-		2023 он	
Биологийн нөхөн сэргээлт шимт хөрс хуулах 1.8 га талбайд	-	-	2023он			
Нийт				1.500		

VIII. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Төслийн хүрээнд нүүлгэн шилжүүлэх үйл ажиллагаа хийгдэхгүй тул БОМТ-нд нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээ тусгагдаагүй болно.

IX. ТҮҮХ СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Уурхайн ашиглалтын үйл явцад түүх соёлын дурсгалт зүйлс олдвол уурхайн үйл ажиллагааг түр зогсоон зохих байгууллагад мэдэгдэж, түүх соёлын дурсгалт зүйлсийг хамгаалах ажлыг зохион байгуулах болно.

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Х. ОСОЛ ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Болзошгүй аюул, осол сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал	Нийт зардал (мян\төг)	Хэрэгжүүлэх хугацаа	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Болзошгүй осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх, байгалийн гамшиг	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Нийт төсөл хэрэгжих талбай барилга байгууламжид	-	-	-	Үйл ажиллагааны турш	Гамшгаас хамгаалах тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Төслийн талбайд болзошгүй осол эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор гал унтраах багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	-	-	0.2	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Галын болон байгалийн аюул гамшгаас урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт, зохион байгуулах	Уурхайн бүх ажилчдад	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Аваар ослын үед авран хамгаалах төлөвлөгөөтэй байх	Үйл ажиллагааны турш	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Эрүүл мэндийн анхан шатны тусламжийн багаж хэрэгсэл байрлуулах.	Уурхайн кемп	-	-	0.3	Үйл ажиллагааны турш	
	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах,	Үйл ажиллагааны турш	-	-	-	1 болон 2-р улиралд	
	Төслийн талбайн эргэн тойрон хашаажуулах	Уурхайн кемп, гол ам	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Техник, технологийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах, Машин техникийн үйлчилгээ засварыг тусгай бэлтгэсэн талбайд явуулж хэвших	Үйл ажиллагааны турш	-	-	-	Үйл ажиллагааны турш	

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

ХI. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал	Тоо хэмжээ	Нийт зардал	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрхзүйн баримт бичиг, стандарт аргачлал
Ахуйн болон хатуу хог хаягдал	Хог хаягдлыг тээвэрлэж Галуут сумын хогийн цэгт зайлуулж байх /сард 1 удаа/ Уурхайн олборлолтын талбайн ойр орчимд үүссэн ил задгай хаягдсан хог хаягдалыг түүж цэвэрлэж байх	-	-	-	-	0.2	Сард 1 удаа	-Ахуйн хог хаягдлыг тээвэрлэхэд тавих ерөнхий шаардлага MNS 5344:2011 -Хог хаягдлын тухай хууль
	Угаах үйлдвэрээс эфель гаалийн хаягдлыг олборлосон талбайд буцааж булах	Уурхайн кемп	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Хаягдал тосыг хуримтлуулах сав байрлуулах	Үйл ажиллагааны турш	-	-	-	0.3	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	
	Орон нутагтай хог хаягдлын гэрээ байгуулах.	Үйл ажиллагааны турш	-	-	-	-	Үйл ажиллагаа эхлэхээс өмнө	

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

XII. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Давтамжийн тоо	Нэгжийн зардал, мян/төг	Нийт зардал, мян/төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга, аргачлал
Хөрсний шинжилгээ						
Хөрсний химийн үзүүлэлт (рН, Давс, ЦДЧ, CO ₂ , Ялзмаг, Ca+Mg, Ca, Mg P ₂ O ₅ , K ₂ O)	Төслийн талбай	Жилд 2 удаа	20.0	40.0	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	MNS 3307:1991, MNS 3308:1991 Хөрс. Хөрсний химийн элементүүдийн нийт хэмжээг тодорхойлох арга, MNS 3309:1991 Хөрс. Хөрсний хялбар уусдаг давсны химийн найрлагыг тодорхойлох арга, MNS 3675:1984 Хөрсний органик бодисын хэмжээг тодорхойлох лабораторийн арга, MNS 4006:1987 Хөрс. Хөдөлгөөнт фосфор, калийг тодорхойлох Мачигины арга MNS 3298:1991 Хөрс. Шинжилгээнд дээж авахад тавигдах ерөнхий шаардлага
Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Cu, Zn)	Төслийн талбай	Жилд 2 удаа	25.0	50.0	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	
Хөрсний эрүүл ахуй (нянгийн тоо, гэдэсний савханцрын титр, анаэробын)	Төслийн талбай	Жилд 2 удаа	25,0	50.0	Ланд овнер хөрс судлалын итгэмжлэгдсэн лаборатори	
Усны чанар						
Усны химийн ерөнхий шинжилгээ (Cl, SO ₄ , NO ₂ , SO ₃ , CO ₃ , NO ₃ , HCO ₃) ерөнхий хатуулгын хэмжээ, исэлдэх чанар, физик шинж чанар	Унд ахуйн усны эх үүсвэрээс	Жилд 2 удаа	46.0	96.0	ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх
Орчны хяналт шинжилгээний нийт зардал					240.0 мян/төг	

БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

XIII. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨГ ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв	Хэрэгжүүлэх хуваарь				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		2023 он					
		I-улирал	II-улирал	III-улирал	IV-улирал		
Ажилчдад байгаль орчныг хамгаалах талаар сургалт зохион байгуулах	-	-	+	-	-	Байгаль орчны мэргэжилтэн	-MNS 4968: 2000 Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа. Эрүүл ахуй. Ерөнхий шаардлага
Байгаль орчны хуваарьт аудитыг хуулийн хугацаанд хийлгэх	Үйл ажиллагааны зардлаар	-	-	+	-	Байгаль орчны мэргэжилтэн, захирал	
Хөдөлмөр аюулгүй байдал эрүүл ахуйн журам гарган ажилчдад мөрдүүлэн ажиллах.	Үйл ажиллагааны зардлаар	+	+	+	+	Захирал	
Уурхайн ажилчдыг хөдөлмөр хамгааллын хувцас хэрэгслээр бүрэн хангах	Үйл ажиллагааны зардлаар	+		+		Захирал	
Яаралтай анхны тусламжид шаардлагатай эм тариа, багаж хэрэгсэлд зарцуулах зардал	0,5	+	+	+	+	Захирал	
Ажилчдыг эрүүл мэндийн үзлэгт хамруулах.	0.5	+				Захирал	
Гал түймрээс урьдчилан сэргийлэх багаж хэрэгсэл байрлуулах.	-	+				Захирал	
Осол эрсдэлийн төлөвлөгөө боловсруулах.	-	+				Захирал	
Нийт							

**БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЛУУТ СУМЫН НУТАГТ ОРШИХ “МУХАР ЭРЭГ, ӨВӨР ЧУЛУУТ, САЙРЫН ХУДАГ” АЛТНЫ ШОРООН ОРДЫГ ИЛ АРГААР АШИГЛАХ
ТӨСЛИЙН 2023 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

**XIV. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН
СУУГЧДАД ТАЙЛАГНАХ**

БОМТ түүний хэрэгжилтийг тайлагнах, хэлэлцүүлэх байгууллагууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэрүүд	Мэдээний агуулга	Хугацааны тов	Хэлэлцүүлгээр санал авах	Зохион байгуулах газар
Бомт-ийн биелэлтийг оршин суугчдад тайлагнах					
БОМТ-ний биелэлтийн үр дүнгийн тайланг төсөл хэрэгжиж буй Баянхонгор аймгийн Галуут сумын нутгийн оршин суугчдад танилцуулж хэлэлцүүлнэ.	Нутгийн оршин суугчдад БОМТ-ний биелэлтийг тайлагнах	БОМТ-ний биелэлт	БОМТ-ын биелэлтийн тайланг 11-р сарын нэгнээс өмнө илгээх	Оршин суугчдын санал гомдлыг хүлээн авч шийдвэрлэх	
Нийт			100,000		